



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 13

Бор-Өндөр

МАЛЫН ТОО ТОЛГОЙД НОГДОХ АЛБАН
ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, 62.4 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт дагаж мөрдөх малын тоо толгойд ногдох албан татварын хэмжээг төрөл тус бүрээр тогтоож нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Малчны амьжиргааг дэмжих зорилгоор өмчилж байгаа малын тоо толгойд ногдох албан татварын хэмжээг төрөл тус бүрээр 0 төгрөгөөр тогтоох малын тоог хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Тогтоолыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулж бүртгүүлэн ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд даалгасугай.
4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Э.МӨНХ-ЭРДЭНЭ


Бор-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
13 дугаар тогтоолын 01-р хавсралт



**МАЛЫН ТОО ТОЛГОЙД НОГДУУЛАХ
АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ**

№	Малын төрөл	Хэмжих нэгж	Төлбөрийн хэмжээ
1	Тэмээ	Нэг толгой	500
2	Адуу	Нэг толгой	1000
3	Үхэр	Нэг толгой	1000
4	Хонь	Нэг толгой	500
5	Ямаа	Нэг толгой	1000

Бор-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
13 дугаар тогтоолын 02-р хавсралт



**МАЛЧНЫ АМЬЖИРГААГ ДЭМЖИХ ЗОРИЛГООР
ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ 0 ТӨГРӨГӨӨР
ТОГТООХ МАЛЫН ТОО**

№	Малын төрөл	Хэмжих нэгж	Тоо толгой
1	Тэмээ	Нэг толгой	5
2	Адуу	Нэг толгой	5
3	Үхэр	Нэг толгой	5
4	Хонь	Нэг толгой	50
5	Ямаа	Нэг толгой	50